



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 1/552

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 5/07, "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Нүүдэлчин Монгол 2022" фестивалд аймаг орон нутгаа төлөөлөн амжилттай оролцсон оролцогчидтой хийсэн зөвлөгөөний зардалд 1,992,840 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Зөвлөгөөний арга хэмжээнд зарцуулагдах 1 992 840 төгрөг (Нэг сая есөн зуун ерэн хоёр мянга найман зуун дөчин)-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.4-д тусгагдсан "Олон үндэстэн ястны өв соёл урлаг" тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Энхболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГ



Т.ДЭЛГЭРСАЙХАН

8400 01 2719
Zan A/552-tum

Аймгийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 29-ний өдрийн
А/552 дугаар захирамжийн хавсралт



АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Зардлын утга	Хүний тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Зөвлөгөөний арга хэмжээний хэрэглэгдэхүүн	60	33214	1 992 840
Нийт				1 992 840

-oOo-